

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖУРМААР ХИЛИЙН ХОРИГ ТАВИХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

CHARACTERISTICS OF LEGAL REGULATION OF BORDER SANCTIONS BY DECISION EXECUTION PROCEDURES

Б.Лхагвасүрэн

Сургалт, судалгааны 403 дугаар анги-

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахлах дэслэгч*

Хураангуй: Өгүүлэлд шийдвэр гүйцэтгэлийн журмаар хилийн хориг тавих эрх зүйн зохицуулалтын талаар судлан үзлээ.

Abstract: In the article, we have studied the legal regulation of border embargo by decision execution procedure.

Түлхүүр үгс: шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хилийг хориг, хязгаарлалт

Keywords: enforcement, border bans and restrictions

Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”¹ гэж заасан.

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. //Төрийн мэдээлэл №1/

Үндсэн хуулиар заасан эрхийг хангах үндэслэлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар баталгаажуулж өгсөн. Уг хуулийг Улсын их хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, 9 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн бөгөөд хуулиар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэслэл, журмыг тогтоосон байдаг.

Дээрх хуулинд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээний талаар тусгагдаагүйгээс тухайн ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2009 оны А/03 дугаар тушаал, 2012 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/62 дугаар тушаалаар батлагдсан журмаар зохицуулж байв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2012 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж байгаа төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх журам"-аар төлбөр төлөгч иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл нь уг журмын "2 дугаар зүйлээр зохицуулсан. Тухайлбал:

2.3.1. Төлбөр төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн,

2.3.2. Эд хөрөнгөө нуун дарагдуулсан,

2.3.3. Эд хөрөнгийн мэдүүлэг өгөөгүй, худал өгсөн,

2.3.4. Гадаад улсад оргон гарч болзошгүй нь тогтоогдсон,

2.3.5. Эрэн сурвалжлагдаж байгаа,

2.3.6 Төлбөр авагч хүсэлт гаргасан бол үнийн дүн харгалзахгүй,

2.3.7 Шүүхээс түдгэлзүүлсэн шийдвэр, захирамж гарсан бол...", "2.4-т 5.000.000 /таван сая/ төгрөгөөс дээш төлбөртэй төлбөр төлөгч, 6 сараас дээш хугацаагаар хүүхдийн тэтгэлэг төлөөгүй тэтгэлэг төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлнэ." гэж заажээ.

Журамд гадаадад зорчих эрх түдгэлзүүлэх үндэслэлийг тодорхой зааж өгсөн боловч зарим зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна.

Тухайлбал, журмын 2.1-т "Шийдвэр гүйцэтгэх алба, хэсэг нь төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналаа албан бичгээр гүйцэтгэлийн хувийн хэргийн хамт Шийдвэр гүйцэтгэх газарт ирүүлнэ" гэсэн зааснаас өөр зохицуулалтгүй байна.

Дээрх эрх зүйн зохицуулалтаас харахад эрх түдгэлзүүлж байгаа талаар төлбөр төлөгч этгээдэд мэдэгдэх, санал хүргүүлэх болон саналыг хүлээн авч шийдвэрлэх хугацаа тодорхой бус, ирүүлсэн саналыг Шийдвэр гүйцэтгэх газар аль

байгууллагад хандаж шийдвэрлэх нь тодорхойгүй, төлбөр авагчийн хүсэлтээр үнийн дүн харгалзахгүй гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж болохоор зохицуусан ч төлбөр авагчийн хүсэлтээр уг эрхийг сэргээх үндэслэлийн талаар огт зохицуулаагүй байгаа юм.

Харин Улсын Их Хурлаас 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002/ хуульд нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Уг нэмэлт өөрчлөлтөөр Улсын ерөнхий гүйцэтгэгчийн бүрэн эрхийг нэмэгдүүлсэн бөгөөд хуулийн 133 дугаар зүйлийн 133.4.4-т “шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх” эрхийг Улсын ерөнхий гүйцэтгэгч хэрэгжүүлэхээр хуульчилсан нь энэ төрлийн албадлагын арга хэмжээ нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд үр нөлөөтэй болсон юм.

Хуулийн зохицуулалтын хүрээнд хилийн хориг тавих ажиллагаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/199 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам”-аар нарийвчлан зохицуулагдаж, өмнөх 2012 оны А/62 тоот тушаалаар баталсан журам хүчингүй болсон.

Тодруулбал тухайн журмаар хилийн хориг тавих ажиллагааг явуулах үндэслэл нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг төлөөгүй, 6 сараас дээш хугацаагаар тэтгэлгийн хуримтлал үүсгэсэн, гадаад улсад зорчих нь холбогдох баримтаар тогтоогдсон төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлах албадлагын арга хэмжээг авах юм.

Шийдвэр гүйцэтгэгч тухай ажиллагааг явуулахдаа төлбөр төлөгчид урьдчилан мэдэгдэх хуудсаар мэдэгдэж, эрх түдгэлзүүлэх саналыг Улсын ерөнхий гүйцэтгэгчид гаргахаар журамлан зохицуулсан.

Түүнчлэн төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг сэргээх үндэслэлийг тодорхойлж, эрх түдгэлзүүлэх, сэргээх ажиллагаанд мэдээлэл харилцан солилцох талаар болон хилээр саатуулагдсан төлбөр төлөгчийг хүлээн авах ажиллагааг ч нарийвчлан зохицуулсан байна.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэлд дээрх журмын 2.5-д зааснаар эд хөрөнгө, орлогоо нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, эд хөрөнгийн мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, худал мэдүүлэг өгсөн, гадаад улсад гарсан нь нотлох баримтаар тогтоогдсон, гадаад улс руу оргон зайлж болзошгүй талаар мэдээлэл ирсэн, эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа зэргийг хамааруулсан.

Шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөрийн үүрэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөр буюу тухайн үеийн мөнгөн дүнгээр 9,6 сая төгрөг, 6 сараас дээш хугацаагаар төлөгдөөгүй, хуримтлал үүссэн тэтгэлгийн хэмжээ нь 1,1-2,2 сая төгрөг байв.

Дээрх журамд энэ төрлийн албадлагын арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгчийн санаачлагаар буюу хариуцсан шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчид мэдэгдэх хуудсаар урьдчилан мэдэгдэж, мэдэгдсэнээс хойш 5 хоногийн дотор харьяалах шийдвэр гүйцэтгэх алба, хэсгээс шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг Шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлж, эрх түдгэлзүүлэх эсэх асуудлыг улсын ерөнхий гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл холбогдох байгууллагад ажлын 5 хоногийн дотор хүргүүлэх, үндэслэлгүй гэж үзвэл санал ирүүлсэн нэгжид мөн 5 хоногийн дотор буцаахаар зохицуулсан байдаг.

Журамд гадаадад зорчих эрх түдгэлзүүлэх ажиллагааг зөвхөн шийдвэр гүйцэтгэгчийн санаачлагаар явуулахаар тусгасан бөгөөд өмнөх 2012 оны А/62 тоот журмаар төлбөр авагчийн хүсэлтээр эрх түдгэлзүүлэх боломжтой байсныг хассан нь учир дутагдалтай зохицуулалт болсон юм.

Харин эрх түдгэлзүүлэх ажиллагааг гүйцэтгэх дараалал, цаг хугацаа, мөн эрхийг буцаан сэргээх үндэслэл журмыг нарийвчлан зохицуулж өгсөн байна.

Тухайлбал, төлбөр төлөгч хуульд заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан, эрх бүхий байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх баримт бичгийг хүчингүйд тооцсон үндэслэлээс гадна төлбөр төлөгч хувийн болон албан ажлаар гадаад улсад зорчих эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагаар зорчих эрхийг түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлуулахаар хүсэлт гаргах, хүсэлтэд гадаад улсруу явах зайлшгүй шаардлагатайг нотолсон хурал зөвлөгөөний хөтөлбөр, урилга, виз, өөрөө эмчилгээ хийлгэх болсон, эсвэл гэр бүлийн гишүүн гадаад улсад нас барсан, гадаад улсад эмчилгээ хийлгэж байгаа гэр бүлийн гишүүний асрах шаардлагатайг нотолсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт, оршин суугаа сум, хорооны Засаг даргын тодорхойлолтыг хавсаргах талаар тодорхой зааж өгчээ.

Дээрх журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийн өмчлөлийн болон үүргийн гүйцэтгэлд барьцаалсан эд хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа, төлбөр төлөгч шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн үндэслэл тогтоогдоогүй зэрэг нөхцөл байдлыг Шийдвэр гүйцэтгэх албанаас хянаж, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг гүйцэтгэхгүй байх чиглэл, зөвлөмжийг харьяа нэгжүүд өгч уг журмын биелэлтэд хяналт тавьж байв.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар улсын хэмжээнд 2016 онд 35908 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 1.1 наяд төгрөгийг барагдуулах

ажиллагаа зохион байгуулагдснаас 150.0 тэрбум төгрөгийн барагдуулж 17721 гүйцэтгэх баримт бичигт явуулах ажиллагааг дуусгавар болгож, гүйцэтгэх баримт бичгийг хаасан ба төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээний үр дүнд 18.1 тэрбум төгрөгийг барагдуулж 489 төлбөр төлөгчдийн хилээр зорчих эрхийг сэргээсэн байна.

Эрх түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээ авагдсан 1577 төлбөр төлөгч нь шүүхийн шийдвэрээр 178.8 тэрбум төгрөгийн төлбөртэй, үүнээс 47 нь гадаад улсын иргэдэд холбогдох 14.3 тэрбум төгрөг, 1530 нь Монгол улсын иргэдэд холбогдох 164.5 тэрбум төгрөгийн мөнгөн төлбөрийн үүрэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны А/199 тоот журмын үйлчлэх хугацаанд улсын хэмжээнд хилээр нэвтрэх эрх түдгэлзүүлсэн 1586 төлбөр төлөгч нь шүүхийн шийдвэрээр 178.8 тэрбум төгрөгийн төлбөртэй, үүнээс 47 нь гадаад улсын иргэдэд холбогдох 14.3 тэрбум төгрөг, 1539 нь Монгол улсын иргэдэд холбогдох 164.5 тэрбум төгрөгийн мөнгөн төлбөрийн үүрэг байжээ¹.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар эрх түдгэлзүүлсэн дээрх үзүүлэлт нь улсын хэмжээнд хилээр нэвтрэх эрх түдгэлзүүлэх арга хэмжээ авагдсан нийт Монгол Улсын иргэдийн 30.0 хувийг, гадаад улсын иргэдийн 24.0 хувийг эзэлж байсан нь энэ төрлийн албадлагын арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байсныг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2016 онд “Гадаадын хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан эсэх асуудлыг судалж дүгнэлт гаргах” ажлын хэсгийг байгуулан Монгол Улсын 5381, гадаадын 191 нийт 5582 иргэнд хилийн хориг тавьсан байснаас тус ажлын хэсгийн саналыг үндэслэн эрх бүхий байгууллагаас Монгол Улсын 202, гадаадын 11 иргэнд тавьсан хилийн хоригийг цуцалж, хууль эрх зүй орчныг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг гаргаж байсан байдаг .

Эрх зүйн зохицуулалтын шинэчлэлд тусгалаа олсон нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2002/ хуулиар төлбөр төлөгч этгээдийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байсныг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулиар шийдвэр гүйцэтгэлийн журмаар хилийн хориг тавих ажиллагааг бүхэлд хориглосон юм.

¹ Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны тайлан.

Тухайлбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /2017/ хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэхийг хориглоно”¹ гэж заасан нь өмнөх хуулийн хүрээнд үйлчилж байсан эрхийг хязгаарлалтыг хориглож Улсын ерөнхий гүйцэтгэгчийн бүрэн эрхэд ч хамааруулахгүй болгосон юм.

Тухай эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр өмнөх хууль үйлчлэх үед эрх түдгэлзүүлсэн 239,5 тэрбум төгрөгийн төлбөртэй Монгол Улсын 1569 төлбөр төлөгч, 20,5 тэрбум төгрөгийн төлбөртэй гадаад улсын 42 төлбөр төлөгчийн хилийн хоригийг цуцлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан байдаг.

Төлбөр төлөгчийн хилийн хоригийг цуцалснаас хойш Шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд 2020 оны 01 дүгээр сарын байдлаар 129,4 тэрбум төгрөгийн төлбөртэй 1851 төлбөр төлөгч Монгол Улсын хилээр орж, гарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан бол 628 төлбөр төлөгч гадаад улсад ажиллаж амьдарч байгаагаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна².

Үүсээд буй нөхцөл байдлын улмаас төлбөр төлөгчид ихээр гадаад улсад зорчих, ажиллаж, амьдрах болсноор Монгол Улсын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр биелэгдэхгүй, хүний хөндөгдсөн эрхийг сэргээх үүргээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгцууллага хэрэгжүүлж чадахгүй байдал үүссэн юм.

Дээрх байдал нь шийдвэр гүйцэтгэлийн журмаар төлбөр төлөгчийн Монгол Улсын хилээр гарах, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсч улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон.

Уг нэмэлт өөрчлөлтөөр шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгч иргэн, төлбөр төлөгч хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж, сэргээх албадлагын арга хэмжээг Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, эсхүл тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж болно”³ гэж заасан.

¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он. //Төрийн мэдээлэл №24

² Шийдвэр гүйцэтгэх албаны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд оруулсан санал. 2018 он.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017 он. //Төрийн мэдээлэл №24

Эрх түдгэлзүүлэх үндэслэлийг 50 саяаас дээш төлбөртэй төлбөр төлөгчийн оршин суух хаяг тодорхойгүйгээс эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг хамааруулсан.

Хуулийн нэмэлт өөрчлөлтийн үед Улсын хэмжээнд 50,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1,6 их наяд төгрөгийн 2533 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаагаас 124,9 тэрбум төгрөгийн төлбөртэй 86 төлбөр төлбөр төлөгч хилээр орж, гарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан, хүүхдийн тэтгэлгийн 46,2 хувь буюу 5223 гүйцэтгэх баримт бичигт холбогдох төлбөр төлөгч хүүхдийн тэтгэлгийн мөнгийг сар бүр төлөөгүй, зайлсхийсэн үйлдлийг гаргасан байжээ.

Хуулиар шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлэхээр зохицуулж, төлбөр төлөгч албан ажлын, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар түр хугацаагаар гадаадад зорчих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах шаардлагатай арга хэмжээ авсны үндсэн дээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түр сэргээхээр зааж өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/40 тоот тушаалаар “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгч этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар шийдвэр гүйцэтгэлийн журмаар гадаадад зорчих эрх түдгэлзүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан юм.

Холбогдох хууль болон журамд зааснаар төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх бүрэн эрхийг Улсын ерөнхий гүйцэтгэгчид хуулиар олгосон бөгөөд шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн тухайн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Хуулийн нэмэлт өөрчлөлтийн нэг онцлог зохицуулалт нь хэрэв нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн шаардлага 50.0 сая төгрөгөөс дээш бол төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ба гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хэсэгчлэн хангасан тохиолдолд мөн төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг хязгаарлаж байгаа нь өөр өөр шүүхийн шийдвэрээр өөр тойрогт төлбөртэй байгаа төлбөр төлөгчид хилээр гарах боломжийг олгож байсныг хязгаарласан юм.

Хуулийг хэрэгжүүлэх үе шат:

Хуулинд заасан гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл бүрдсэн гэж үзвэл хариуцсан тойргийн шийдвэр гүйцэтгэгч нь энэ талаар төлбөр төлөгчид мэдэгдэх хуудсаар мэдэгдэж, мэдэгдсэнээс хойш 3 хоногийн дотор гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь саналыг хянаж Шийдвэр гүйцэтгэх албанд даруй хүргүүлэх бөгөөд саналыг Шийдвэр гүйцэтгэх албаны дарга хянан шийдвэрлэж, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл тогтоогдоогүй, ирүүлсэн баримт нь шаардлага хангаагүй тохиолдолд саналыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор ирүүлсэн нэгжид буцаана.

Энэхүү зохицуулалт нь өмнөх журмуудад хэт ерөнхийлөн зохицуулсан заалтуудыг илүү нарийвчлан тусгаснаараа онцлогтой. Мөн гадаадад зорчих эрхийг сэргээх санал гаргах, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар ч нарийвчлан зохицуулж өгсөн юм.

Тухайлбал, гадаадад зорчих эрхийг сэргээх үндэслэлийг тодорхойлж өгсөн бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсонд тооцсон эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр гарсан, гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр гарсан, хуримтлагдсан хүүхдийн тэтгэлийг нөхөн төлүүлсэн, тэтгэлгийн үлдэгдэлгүй болсон тухай шийдвэр гүйцэтгэгчээс ирүүлсэн саналын үндэслэлийг тусгаж өгсөн юм.

Түүнчлэн гадаадад зорчих эрхийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас түр сэргээх асуудлыг зохицуулсан бөгөөд төлбөр төлөгч албан ажлаар эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар гадаадад зорчих шаардлага үүссэн бол эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас томилолтоор ажиллуулах шаардлага, явах, ирэх хугацааг тодорхойлж, гадаадад зорчих эрхийг түр сэргээх саналыг бичгээр ирүүлсэн бол, төлбөр төлөгч гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагыг нотолсон эрх бүхий эмнэлгийн байгууллагын мэргэжлийн комиссын дүгнэлт гарсан бол, гадаадад зорчих эрхийг түр сэргээх талаар төлбөр төлөгч, төлбөр авагч этгээд бичгээр хүсэлт гаргасан бол шийдвэрлэхээр зохицуулсан.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг сэргээх боломжгүй тохиолдол нь нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн бол нийт гүйцэтгэх баримт бичгийн шаардлага бүрэн хангагдснаар тухайн төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг сэргээхээр заасан нь төлбөрийн шаардлагын үлдэгдэл хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага хэмжээтэй байсан ч үлдэгдэл төлбөрийг бүрэн төлөөгүй байх тохиолдлыг хамааруулна.

Нөгөөтэйгүүр практикт шүүхийн шийдвэрийн дагуу 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй төлбөрийн шаардлагаа биелүүлээгүй Монгол Улсын иргэдээс гадна гадаад улсын иргэд цөөнгүй байна.

Гадаадын иргэний Монгол Улсаас гарах эрхийг түдгэлзүүлэх талаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулсан байдаг .

Хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дах хэсэгт зааснаар:

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу тухайн гадаадын иргэнийг Монгол Улсаас гарах, гарахыг түр түдгэлзүүлэх тухай шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол, хуулийн 34.3-т “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх тухай шийдвэрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга холбогдох байгууллагын саналыг үндэслэн гаргана”.

Уг хуулийн 34.4.-т “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 34.3-т заасан шийдвэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ” гэж заасан байдаг.¹

Мөн гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/111 дүгээр тушаалаар “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт гадаадын иргэнийг гарахыг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан үндэслэлээр шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон прокурорын байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.”² гэж баталсан.

“Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам”-ын 2.8 дахь хэсэгт “Гарахыг түдгэлзүүлэх шийдвэр гарсан даруйд гарахыг түдгэлзүүлэх шийдвэр хариуцсан албан хаагч нь мэдээллийг гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, шийдвэр гарснаас хойш 24 цагийн дотор гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хил хамгаалах

¹ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2010 он. //Төрийн мэдээлэл №32

² Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам. 2017 он.

байгууллага, орон нутаг дахь хилийн боомт, санал ирүүлсэн эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.”¹ гэж зохицуулсан байна.

Эдгээр зохицуулалтын дагуу төлбөр төлөгч гадаадын иргэний хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг гадаадын иргэн, харьяатын газарт хүргүүлэн тус газрын даргын тушаалаар эрхийг түдгэлзүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноос хойш буюу 2020 оны 01 сарын 10-ны өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 50 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийн шаардлагаа биелүүлээгүй, тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй үндэслэлээр иргэн болон хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан нийт 7223 иргэн, үүнээс хүүхдийн тэтгэлэг төлөгч 4900 иргэн, гадаад улсын 63 иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлээд байна.

---o0o---

¹Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх журам. 2017 он.